



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/328

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Монголын ирээдүй хүүхэд багачууд-Зөв Монгол хүн бүрийн төлөө” уриан дор зохион байгуулах “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан “Нийгмийн хөгжилд-Залуу ээжүүдийн оролцоо” сэдэвт урлаг, соёл, танин мэдэхүйн соён гэгээрүүлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах зардалд 2 700 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 2 700 000 төгрөг /Хоёр сая долоон зуун мянган/-ийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, арга хэмжээний 5.16-д тусгагдсан “Гэр бүлийн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны
05 дугаар сарын 27-ны өдрийн
А/328 дугаар захирамжийн хавсралт



“НИЙГМИЙН ХӨГЖИЛД-ЗАЛУУ ЭЭЖҮҮДИЙН ОРОЛЦОО”
СЭДЭВТ УРЛАГ, СОЁЛ, ТАНИН МЭДЭХҮЙН СОЁН
ГЭГЭЭРҮҮЛЭХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

№	Үйл ажиллагааны зардал	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт
1	Ванер хэвлүүлэх	25 м,кв	10000	250 000
2	Тайз чимэглэх шаар	200 ш	500	100 000
3	Сүү	420	2700	1 134 000
4	Мэдээлэл, сурталчилгааны материал	420	2800	1 176 000
5	Театрын түрээс			100 000
	Нийт			2 760 000

-oOo-